## ХОРИО ЦЭЭРИЙН ХЭЛТСИЙН ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТ ХАРИУЦСАН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ С.БОЛОРМААГИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт арга хэмжээний биелэлт**

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхлэсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 2. Хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах** | | | | | | | |
| 1. | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал /хүний хөл хориот өвчин, мал, амьтны гоц халдварт өвчин, ургамлын хорио цээртэй зүйлс, химийн болон цацрагийн осол, хордлого, хүнсний аюулгүй байдлын өөрчлөлт /-аас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааны талаар харьяа гаалийн газар, хороодыг мэргэжлийн удирдлагаар тухай бүр хангаж ажиллана.<br><br>3. Улсын хилээр нэвтэрч буй зорчигчдод тавьж буй эрүүл мэндийн хяналт тандалтын мэдээг улирал бүр нэгтгэн ГЕГ-ын удирдлага, холбогдох мэргэжлийн байгууллагуудад, сэжигтэй үйл явдал, тохиолдлын мэдээг тухай бүр мэдээлнэ.<br><br>5. Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлгийн хуудсыг бөглөх гар утасны аппликашионыг зорчигчийн эрүүл мэндийн хяналт тандалтын үйл | 1.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал /хүний хөл хориот өвчин, мал, амьтны гоц халдварт өвчин, ургамлын хорио цээртэй зүйлс, химийн болон цацрагийн осол, хордлого, хүнсний аюулгүй байдлын өөрчлөлт /-аас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааны талаар харьяа гаалийн газар, хороодыг мэргэжлийн удирдлагаар тухай бүр хангаж ажилласан.<br><br>2. Улсын хилээр нэвтэрч буй зорчигчдын эрүүл мэндийн хяналт, тандалтыг тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байгаа ба халдвар судлалын заалтаар Улаан бурхан өвчний тандалтыг агаарын замын боомт дээр хэрэгжүүлэн ажиллаж, өдөр тутмын мэдээллийг авч, нэгтгэн ажиллав. 2025 оны 03 дугаар сарын 30-аас хойш Тайланд /Бангкок/, /Фукет/, Вьетнам /Хошимин/, /Ханой/, /Дананг/, /Фукуок/, /Натранг/ чиглэлүүдэд нислэг үйлдээгүй байна. Хяналт тандалтын дүнд халдварын сэжигтэй, халдвартай зорчигч илрээгүй байна.<br><br>3. Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлгийн хуудсыг цахимжуулах, гар утасны аппликэйшнийг туршилтад нэвтрүүлсэн. | 2025.01.01<br>2025.06.10 | 92% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ажиллагаанд нэвтрүүлнэ.<br><br>6. Нийгмийн эрүүл мэндийн аюулгүй байдлын өөрийн үнэлгээний аргачлалыг боловсруулж батлуулан, олон улсын шинжтэй автозамын 2 боомт, хоёр талын шинжтэй автозамын 2 боомт, олон улсын агаарын хилийн 1 боомт, нийт 5 боомтод үнэлгээ хийж, тайлагнана.<br><br>7. Харьяа гаалийн газар, хороодын "Нийгмийн эрүүл мэндийн Бэлэн байдлын төлөвлөгөө"-нд дүн шинжилгээ хийж, нэг загварт оруулна.<br><br>8. МУ-ын Гаалийн ерөнхий газар, БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар хоорондын "Хилийн эрүүл ахуй, хорио цээрийн хамтын ажиллагааны протокол"-ыг хэрэгжүүлэх хүрээнд Замын-Үүдийн нутаг дэвсгэр болон БНХАУ-тай хиллэдэг зарим нутаг дэвсгэрт 2 улсын мэргэжлийн байгууллагатай хамтран зоонозын халдварт өвчний тандалтыг хийнэ.<br><br>9.МУ-ын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын "Хилийн усыг ашиглах, хамгаалах хэлэлцээр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд хил дамнасан усаар дамжих эрсдэл бүхий халдвараас сэргийлэх зорилгоор эрүүл ахуйн шинжилгээтэй тандалт хийнэ. | 4. ДЭМБ-ын JEE үнэлгээний аргачлалд үндэслэн үндэсний хэмжээний хилийн боомтуудыг үнэлэх асуумж боловсруулан 2025 оны 04 сарын 25-ны өдөр хэлтсийн албан хаагчдаар, 28-ны өдөр ХӨСҮТ, ЗӨСҮТ-ийн мэргэжилтнүүдийн түвшинд хэлэлцүүлэг тус тус зохион байгуулан, санал зөвлөмжийг тусгав. 2025 оны 05 сарын 07-ны өдөр үнэлгээ хийх 5 боомтруу албан бичгээр хавсарган илгээсэн. 2025.05.28-ны өдөр ДЭМБ-ын төлөөлөгчидтэй "Хилийн нэвтрэх цэгт нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээ авах, үйл явдлыг илрүүлэх, эрт сэрэмжлүүлэх үйл ажиллагаанд стратегийн эрсдэлийн үнэлгээ"-ний асуумжны хэлэлцүүлэг хийж, санал солилцов. Хэлэлцүүлгийн дүнд Монгол Улсын хилийн боомтын чадавхийг үнэлэх асуумжийг сайн болсон гэж үнэлсэн бөгөөд ДЭМБ-ын төлөөлөгчдийн зүгээс 5 санал тусгуулллаа.2025.05.09-өөс 2025.05.14-ний хооронд хилийн Ханги, Замын-Үүд боомт дээр ажиллаж, "Хилийн нэвтрэх цэгийн нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээ авах, үйл явдлыг илрүүлэх, эрт сэрэмжлүүлэх үйл ажиллагаанд стратегийн эрсдэлийн үнэлгээ"-г хийсэн. Үнэлгээний дүнг нэгтгэж, зурган танилцуулга, тайлан, зөвлөмж боловсруулав. Үнэлгээгээр Ханги боомт 3-р түвшин буюу чадавхижиж байгаа, Замын-Үүд боомт 4-р түвшин буюу чадавхитай гэж үнэлэгдсэн.<br>Замын-Үүд боомтод сум орон нутгийн түвшинд 3, боомтын хэмжээнд 2, гаалийн газрын хэмжээнд 6, Ханги боомтод сум орон нутгийн түвшинд 3, боомтын хэмжээнд 4, гаалийн газрын хэмжээнд 8 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн.<br><br>5. Гаалийн ерөнхий газрын даргын баталсан "Хилийн нэвтрэх цэгт нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээ авах, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үйл явдлыг илрүүлэх, эрт сэрэмжлүүлэх үйл ажиллагаанд стратегийн эрсдэлийн үнэлгээ хийх” ажлын удирдамжийн хүрээнд 2025 оны эхний хагас жилд хилийн Ханги, Замын-Үүд, Чингис хаан боомтуудад газар дээр нь үнэлгээг хийсэн. Үнэлгээний асуумжны хүрээнд тус боомтын “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-нд дүн шинжилгээ хийлээ. Цаашид удирдамжид заагдсан хилийн Алтанбулаг, Сүхбаатар, Арцсуурь зэрэг боомтууд дээр үнэлгээ хийх ба төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийн нэгтгэж, цаашид нэгдсэн төлөвлөгөөний загварын төслийг боловсруулав.<br><br>6.ГЕГ-ын даргын 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/176 тоот “Уулзалтад оролцуулах тухай” тушаалын дагуу МУ-ын ГЕГ, БНХАУ-ын ГЕГ хооронд байгуулсан “2022 оны Хилийн эрүүл ахуй, хорио цээрийн хамтын ажиллагааны протокол”-ыг хэрэгжилтийг хангуулах хүрээнд ЗӨСҮТ, ХӨСҮТ-тэй хамтран, БНХАУ-ын Хөх хот, Эрээн ГГ-тай хамтран 2025 оны 05 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд БНХАУ-ын Эрээн хотод болсон уулзалтад ГЕГ-ын ХЦХ-ийн ГУАБ Т.Төмөрбаатар, Замын-Үүд ГГ-ын ХЦА-ны дарга Ц.Болдоо нарын хамт оролцов.<br>Уулзалтын мөрөөр 4 заалтаар /Монгол, Хятадын хилийн боомтуудын мэрэгчээр дамжих зоонозын халдварт өвчний хамтарсан тандалт, хилийн эрүүл ахуй, хорио цээрийн асуудлаар хэлэлцээр, эрдэм шинжилгээний хурал, үзүүлэх сургууль/ 2025 онд ажлыг төлөвлөж, хурлын тэмдэглэлийг үйлдэж, Хөх хотын ГГ, МУ-ын ГЕГ-ын ХЦХ, ӨМӨЗО-ны Өвчнөөс урьдчилан сэргийлэх төв, МУ-ын ЗӨСҮТ-ийн талаас баталгаажуулав. Тус уулзалтын илтгэх хуудас, хэвлэлийн мэдээллийг бэлтгэсэн. Хил залгаа улсын гаалийн байгууллага, эрүүл мэндийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллагын уялдаа холбоо сайжирч, мэдээ мэдээлэл солилцох, хамтын ажиллагаа сайжирсан.<br><br>7. Хил дамнасан усанд эрүүл ахуй, тархвар судлалын тандалт хийх удирдамжийг боловсруулж, холбогдох удирдлагуудаар хянуулан 02/2323 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br><br>**Хүрсэн үр дүн:** Хил залгаа улсын хилийн хяналтын байгууллагатай хийсэн хэлэлцээрийн биелэлт хангагдан, уялдаа холбоо сайжирч, мэдээ мэдээлэл солилцох, хамтын ажиллагаа сайжирсан. Үндэсний хэмжээний “Хилийн нэвтрэх цэгт нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээ авах, үйл явдлыг илрүүлэх, эрт сэрэмжлүүлэх үйл ажиллагаанд стратегийн эрсдэлийн үнэлгээ хийх” асуумжтай болсноор цаашид сайжруулан ашиглах, боомтын чадавхийг үнэлэх боломжтой болсон. Үнэлгээ хийгдсэн боомтуудын хувьд чадавхжиж байгаа болон чадавхжсан гэж үнэлэгдсэн ба цаашид нийт боомтын чадавхийг үнэлж, суурь үзүүлэлттэй болох бөгөөд шат дараалласан арга хэмжээ авч боомтуудын чадавхийг дээшлүүлэх боломжтой болсон. | | |
| 2. | Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1.Улсын хилээр нэвтрүүлж буй хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан хяналт, шалгалт хийх ажлыг зохион байгуулах, харьяа газар, хороодыг мэргэжлийн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллана.<br><br>2.Хяналт, шалгалтын үйл ажиллагаа, тайлан мэдээнд дүн шинжилгээ хийж, цаашид | 1. Гаалийн ерөнхий газрын даргын баталсан “Бүрдүүлэлтийн цахим төвийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ гүйцэтгэх ажлын удирдамж”-ийн хүрээнд CAIS системд 2024 онд бүртгэгдсэн 961900 кодтой барааны хяналтын тайланд дүн шинжилгээ хийж нэгтгэн ажлын хэсэгт хүргүүлсэн.<br>2. Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр боловсруулсан 2 цахим заавварт / Биологийн халдвартай материал, донорын эд эрхтэн, Хуучин хувцас/ заалт тус бүрээр санал тусган | 2025.01.01<br>2025.06.10 | 91% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.<br><br>3.Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамаарагдаг барааны 47 төрлийн заавпыг эцэслэн боловсруулан, баталгаажуулж, цахимаар ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ. | эцэслэж Б.Батбилэг, Ц.Отгонбор нарт цахимаар илгээсэн. Мөн хорио цээрийн программын тээврийн хэрэгслийн бүртгэл хэсэгт 1, халдваргүйжүүлэлт хэсэгт 7, сэрэмжлүүлэг мэдээний хэсэгт 5 агуулга бүхий, шарил чандарын бүртгэл хэсэгт 9 санал тус тус өгч ажилласан.<br>**Хүрсэн үр дүн:** хорио цээрийн программын модулийн гүйцэтгэлийн үр дүн сайжирч, хэрэглээнд нэвтрэхэд бэлэн болсон.<br>Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр хяналт шалгалт хийж буй гаалийн улсын байцаагчдын баримт бичгийн хяналтад дүн шинжилгээ хийснээр цаашид анхаарах асуудлуудыг тодорхойлсон. Цаашид хяналтын бусад чиглэлийг шат дараатайгаар баримт бичгийн хяналт дээр дүн шинжилгээ хийж, хяналт шалгалтын үр дүнг сайжруулна. | | |
| **Зорилт 1.Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх** | | | | | | | |
| 6 | Гадаад худалдааг хөнгөвчлөх хүрээнд хорио цээрийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | 3. Гадаад худалдаа эрхлэгчдэд хууль тогтоомжийг сурталчлах, зохион байгуулах чиглэлээр Олон нийттэй харьцах албатай хамтран байгууллагын вэб хуудсаар зөвлөмж, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулна. . | 3. “Халдварт өвчнөөс өөрийгөө болон хайртай дотны хүнээ хамгаалаарай” сэдэвт аялагчдад зориулсан зөвлөмж боловсруулж, ЗУГ-т хүргүүлсэн.<br>**Хүрсэн үр дүн:** Сурагчдын амралт эхлэж, аялал жуулчлал ихэсдэг үеэр зорчигчдод чиглэсэн халдвараас сэргийлэх зөвлөмж боловсруулж, ОУЭМД-ээр зохицуулагддаг, хүний хөл хориот халдварт өвчин хил нэвтрэх, дамжин тархахаас сэргийлэх чиглэлд ажилласан | 2025.01.01<br>2025.06.10 | 90% |
| **Зорилт 3. Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 8 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | 1.Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын чиглэлийн хууль тогтоомжийн биелэлтийг хангуулж ажиллан, илэрсэн зөрчил дутагдалд дүн шинжилгээ хийнэ.<br><br>2.ГЕГ-ын даргын 2019 оны | 1.2025 оны 04 дүгээр сарын зөрчлийн мэдээллийг нэгтгэж, дүн шинжилгээ хийсэн.<br>2. 1.“Хүнсний тухай хууль”-ийн төсөлд хүнсний хяналтын чиглэлтэй хамтран 3 санал өгсөн. Үүнд: 1. Импортын хүнсний хадгалалтын хугацааны 2/3 хүчинтэй байх гэсэн заалтыг хадгалалтын хугацаа хүчин төгөлдөр байх гэж өөрчлөх | 2025.01.01<br>2025.06.10 | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 275 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-ыг шинэчлэхэд хорио цээрийн чиглэлэр саналыг өгч ажиллана.<br><br>3. Хорио цээрийн чиглэлээр хөрш зэргэлдээ болон бусад улсын мэргэжлийн байгууллагатай санамж бичиг, протоколыг байгуулахад санал өгч ажиллана. | 2.Зорчигчийн хувийн хэрэглээний хүнсний асуудлыг журмаар зохицуулах гэж тусгах<br>3. Экспорт, импортын хүнсийг Гаалийн болон хорио цээрийн хяналтаар гэснийг тодорхой тусгах<br><br>"Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам" /төсөл/-д нийт 32 санал өгсөн.<br><br>3.ГЕГ-ын даргын 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/176 тоот "Уулзалтад оролцуулах тухай" тушаалын дагуу МУ-ын ГЕГ, БНХАУ-ын ГЕГ хооронд байгуулсан "2022 оны Хилийн эрүүл ахуй, хорио цээрийн хамтын ажиллагааны протокол"-ыг хэрэгжилтийг хангуулах хүрээнд БНХАУ-ын Хөх хот, Эрээн ГГ-тай хамтран 2025 оны 05 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд БНХАУ-ын Эрээн хотод болсон уулзалтад ГЕГ-ын ХЦХ-ийн ГУАБ Т.Төмөрбаатар, Замын-Үүд ГГ-ын ХЦА-ны дарга Ц.Болдоо нарын хамт оролцсон. Уг хэлэлцээрийн явцад санал солилцож, тухайн жилд хийх ажлын төлөвлөлтийг батлуулсан.<br>**Хүрсэн үр дүн:** Гаалийн газар хороодод хорио цээрийн хяналтын чиглэлээр илрүүлсэн зөрчил дутагдлын мэдээлэлд дүн шинжилгээ хийх боломжтой болсон.<br>Гадаад хамтын ажиллагаа сайжирсан.<br>"Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам" /төсөл/ боловсруулагдан, хил гүний хяналт шалгалт хийж буй эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналт хариуцсан гаалийн улсын байцаагчдын ажиллах эрх зүйн орчин тодорхой болоход нэг шат ахисан. | | |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхлэсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Албан хэрэг хөтлөлт /Edoc программаар цохогдсон албан бичгийн хэрэгжилт/ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Хугацаатай үүрэг даалгаврын биелэлт хангагдсан байна. | Тайлант хугацаанд Edoc программаар цохогдсон 28 албан бичгээс дотоод 15, бусад байгууллагаас 13 албан бичгийг шийдвэрлэсэн. Үүнд:<br>Бүрэн шийдвэрлэсэн 25, шилжүүлсэн 1, хянагдаж байгаа 2 албан бичиг байна.<br>Явсан нийт 24 албан бичгээс Гаалийн ерөнхий газрын Зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагуудад 7, бусад байгууллагуудад 17 албан бичиг тус тус төлөвлөн хүргүүлсэн.<br>**Хүрсэн үр дүн:** Edoc программаар цохогдсон хугацаатай албан бичгийн хэрэгжилт хангагдсан. | 2025.01.01<br>2025.06.10 | 93 % |
| 2 | Боомтын бүтээн байгуулалтын ажлын хэсгийн хуралд оролцож, санал өгөв | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Хорио цээрийн хэлтсийн даргын өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангагдана. | Шивээхүрэн боомтын бүтээн байгуулалтын зураг төслийн гүйцэтгэгчтэй хийсэн хуралд суусан, зураг төсөлтэй холбоотой 2 санал оруулсан. /Мал амьтны тусгаарлах байгууламжны байршлыг зонхилох салхины доор байрлуулах боломжийг судлах, аюултай хог хаягдлын цэг/<br>**Хүрсэн үр дүн:** Тус боомтын бүтээн байгуулалтын зураг төсөлд аюултай хог хаягдлын цэгийг тусгуулсан мөн мал амьтны тусгаарлах байгууламжны байршлыг зөв чиглэлд төлөвлүүлсэн. | 2025.01.01<br>2025.06.10 | 92% |
| 3 | Төлөвлөгөөний биелэлтийн танилцуулга бэлтгэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Хорио цээрийн хэлтсийн даргын өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангагдана. | Хэлтсийн 2025 оны 1-р улирлын төлөвлөгөөний биелэлтийн танилцуулга PPT бэлтгэсэн.<br>**Хүрсэн үр дүн:** Хяналт бүрдүүлэлтийн газрын нэгдсэн төлөвлөгөөний биелэлтийн танилцуулгад хорио цээрийн хэлтсийн мэдээллийг бүрэн тусгасан. | 2025.01.01<br>2025.06.10 | 93% |
| 4 | Хурлын тэмдэглэл хөтлөх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Хорио цээрийн хэлтсийн даргын өгсөн үүрэг даалгаврын | 2025.04.04-ний өдөр газар хороод дахь хорио цээрийн хүний нөөц, бүтцийн асуудлаар хэлэлцсэн хурлын тэмдэглэл хөтөлж, баталгаажуулав. | 2025.01.01 | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | биелэлт хангагдана. | "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам" /төсөл/-д хорио цээрийн хэлтсээс оруулах саналын хэлэлцүүлгийн явцын тэмдэглэлийг хөтөлсөн. **Хүрсэн үр дүн:** Хурлын тэмдэглэлийг хөтөлж, хурлын дунд гарсан шийдвэрийн төслийг баримтжуулсан. | 2025.06.10 | |
| 5 | Сангийн сайдын 18 дугаар тушаалын биелэлт гаргах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Хорио цээрийн хэлтсийн даргын өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангагдана. | Хэлтсийн даргын үүрэг болгосны дагуу Сангийн сайдын 18 дугаар тушаалын 4.3 дахь заалтын биелэлтийг гаргаж татвар орлогын газарт илгээсэн. **Хүрсэн үр дүн:** Сайдын тушаалын хэрэгжилтийг хорио цээрийн хяналтын чиглэлээр хугацаанд нь гаргаж өгсөн. | 2025.01.01<br>2025.06.10 | 94% |

**Нэг. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхлэсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино, дунд хугацааны болон цахим сургалтад хамрагдах | Сургалтын тоогоор | - | Гаалийн хэргийн анхан шатны мэдлэг эзэмших<br><br>Багшлах ур чадвартай болох<br><br>Англи хэлний 4-р түвшин | 1.Хорио цээрийн чиглэлийн ГУБ нарт зориулсан чиглүүлэх сургалтад 2025.05.19-30-ныг дуустал хамрагдаж, сертификат гардаж авсан.Гаалийн хэргийн анхан шатны мэдлэгтэй болсон.<br><br>2.Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Нээлттэй боловсролын хүрээлэнгийн "Багшлах эрхийн сургалт"-д 1 сарын турш суралцан, амжилттай дүүргэж, багшлах эрхийн (895/Модуль А) сертификатаа гардан авсан.<br><br>3.2025.04.02-2025.05.02-ны хооронд "Talk talk english" | 2025.01.01<br>2025.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сургалтын төвд суралцан, англи хэлний түвшингээ 1 шатаар ахиулсан. | | |
| 2 | Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна. | Хүүхэд асрах чөлөөний хугацаанд шинэчлэн найруулагдсан хууль тогтоомжуудыг уншиж, судалсан.<br><br>1.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль<br>2. “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам” -ын төсөл | 2025.01.01<br>2025.06.10 | 100% |

Тайлан гаргасан:

Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналт хариуцсан
Гаалийн улсын байцаагч ........................................ /С.Болормаа/ 2025 оны 06 сарын 10 өдөр

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ С.БОЛОРМААГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Хорио цээрийн хэлтэс

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 2. Хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах** | | | | | |
| 1 | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах | 56,7 | 8 | 64,7 | |
| 2 | Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийх | 55 | 8 | 63 | |
| **Зорилт 1.Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх** | | | | | |
| 3 | Гадаад худалдааг хөнгөвчлөх хүрээнд хорио цээрийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлэх | 54 | 8 | 62 | |
| **Зорилт 3. Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх** | | | | | |
| 4 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжүүлэх | 52 | 8 | 60 | |
| 5 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | 53 | 8 | 61 | |
| 6 | Үүрэг даалгаврын биелэлт | 54 | 8 | 62 | |
| 7 | Ажлын цаг ашиглалт | 57 | 8 | 65 | |
| 8 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | 55 | 6 | 61 | |
| **Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт** | | | | | |
| 9 | Даргын өгсөн үүрэг даалгавар болон албан бичгээр ирсэн агуулгын дагуу сургалт, семинар хэлэлцүүлэгт оролцох, үүрэг даалгаварыг биелүүлэх | 54 | 8 | 62 | |
| **Дундаж оноо:** | | | | **62,3** | |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | Байгууллагаас зохион байгуулж буй сургалтад хамрагдаж хувь хүний хөгжил, мэдлэг ур чадвараа дээшлүүлэх | 100 | 15 | |
| 2 | Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | 100 | 15 | |
| | **Дундаж оноо:** | | 15 | |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1 | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2 | Дүн шинжилгээ хийх | 7 | |
| 3 | Асуудал шийдвэрлэх | 6 | |
| 4 | Хариуцлагатай байдал | 6 | |
| 5 | Ажлын цаг ашиглалт | 6 | |
| | **Дундаж оноо:** | **6,4** | |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Хандлага, ёс зүй, ур чадвар | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1 | Хандлага, ёс зүй | 8 |
| 2 | Багаар ажиллах | 7,8 |
| 3 | Харилцаа | 7,7 |
| | **Дундаж оноо:** | **7,8** |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)* | 62,3 |
| 2 | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 15 |
| 3 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | 6,4 |

| | | |
|---|---|---|
| 4 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Хамт олны үнэлгээ)* | 7,8 |
| 5 | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо =**<br>(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* )- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | **91,5** |

***Үнэлгээ өгсөн:***

***Нэгжийн дарга:***
Хорио цээрийн хэлтсийн дарга ............................... (Г.Батмөнх)

2025.06.10 .........................*(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

***Төрийн жинхэнэ албан хаагч:***
Гаалийн улсын байцаагч ...........................................(С.Болормаа)

2025.06.10 ............................*(огноо)*

***Үнэлгээг хянасан :***

***Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:***
Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ................................ (Г.Энхтайван)

2025.06.25 ......................... *(огноо)*

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***
Хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын ахлах байцаагч ............................(Ө.Тэгшээ)

2025.06.25 ..................... *(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:***

***Төсвийн шууд захирагч:***
Гаалийн ерөнхий газрын дарга ............................... (Р.Отгонжаргал)

2025.06.25 ..................................*(огноо)*